




# 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

 (976) – 7021 0114

 [www.baganyurmine.mn](http://www.baganyurmine.mn)

Улаанбаатар хот,  
Багануур дүүрэг-12150,  
3-р хороо, Багануур ХК



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН  
**ОСОЛ** **0**

**АГУУЛГА**

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	5
Ерөнхий мэдээлэл	6
Үндсэн үйл ажиллагааны статистик	7
Төлөөлөн удирдах зөвлөлийн мэндчилгээ	10
Алсын хараа, эрхэм зорилго	15
Бүтэц зохион байгуулалт	16
Байгаль орчны хяналт, нөхөн сэргээлт	20
Хүний нөөц	26
Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй	30
Хамтын ажиллагаа	36
Аудитын тайлан	40



## БАГАНУУР ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.НОМИНЧУЛУУН

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Багануурын уурхай нь улс орныхоо төвийн бүсийг эрчим хүчний нүүрсээр тасралтгүй, найдвартай хангах үндсэн үүргээ биелүүлэн ажиллалаа.

2020 онд уурхайчин хамт олон маань үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт болох нүүрс олборлолт, борлуулалтын төлөвлөгөө 101.3 хувь, хөрс хуулалтын төлөвлөгөө 93.9 хувь, нийт уулын цулын ажлыг 101.8 хувьтай биелүүлж ажилласан.

Уурхайн техник шинэчлэлийн чиглэлээр Японы Олон улсын хамтын ажиллагааны банкнаас /JBIC/ 29,7 тэрбум төгрөгийн зээлийн асуудлыг амжилттай шийдвэрлүүлэн нийт 12 техникийг авахаар болсон.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт Багануурын уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх, техникийн дараагийн шатны өргөтгөл хийх шаардлагатай 33.6 тэрбум төгрөгийн /9 техник/ хөрөнгө оруулалтыг тусгуулсан. Ингэснээр эрчим хүчний тасралтгүй нэмэгдэх хэрэгцээг хангах боломж бүрдэж байна.

**“ Бид 2021 оныг “Хэмнэлт, бүтээмжийн жил” болгон зарласан бөгөөд санхүүгийн болон үйл ажиллагааны дотоод нөөц бололцоогоо дайчлан үргүй зардлыг бууруулах, шаардлагатай нөхцөлд дотоод дүрэм журамд өөрчлөлт оруулах, санхүүгийн нөхцөлд тохируулан ажлын бодит бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр олон тал арга хэмжээ авч ажиллахаар төлөвлөж байна.**

Ирэх онд бид бодлогын хувьд компанийн дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, технологийн хувьд хөрс тээвэрлэлтийн зайг богиносгох зорилгоор нүүрс бутлан ачих хэсэг хоёрын төмөр замыг шилжүүлэх ажлыг дуусгах, уулын дэд станцыг нүүлгэн шилжүүлэх зэрэг томоохон ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Ингээд 2020 онд бидэнтэй хамтарч ажилласан салбарын яам, Эрдэнэс Монгол ХХК, хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, дүүргийн төр захиргааны байгууллага болон хамтрагч байгууллагууд та бүхэндээ баярлаж талархсанаа илэрхийлж, цаашид урт хугацаанд хамтран ажиллана гэдэгт итгэж буйгаа илэрхийлье.

Та бүхний ажил үйлсэд арвин их амжилт хүсэн ерөөе.

### ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ




Э.НОМИНЧУЛУУН

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



**1978** онд  
байгуулагдсан




**1128**  
ажилтантай



**75.00%** "Эрдэнэс  
Монгол" ХХК  
**21.06%** Монголиан  
коал корпорейшн  
**3.94%** Жижиг



**Тээвэртэй  
Тээвэргүй**  
хосолсон  
ашиглалтын  
систем



НӨӨЦ  
**787,0**  
сая.тонн




ЖИЛИЙН ХҮЧИН  
ЧАДАЛ  
**4,0** сая.тонн




НҮҮРСНИЙ  
ИЛЧЛЭГИЙН  
СТАНДАРТ  
**3360** ккал/кг

## ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК


ХӨРС ХУУЛАЛТ /мян.мЗ/



ХӨРС ХУУЛАЛТЫН КОЭФФИЦИЕНТ




НҮҮРС БОРЛУУЛАЛТ /мян.тн/




НҮҮРСНИЙ ДУНДАЖ ИЛЧЛЭГ /ккал.кг/




ТЭСЭЛСЭН УУЛЫН ЦУЛ /мян.мЗ/




ӨРӨМДЛӨГИЙН АЖИЛ /мян.метр/




**БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ**




**ТАТВАР ХУРААМЖ /ТЭРБУМ.ТӨГ/**




**УС ШҮҮРҮҮЛЭЛТ /мян м3/**




**АЮУЛЫГ МЭДЭЭЛЖ АРИЛГАЛТ**



**ТЕХНИК АШИГЛАЛТЫН КОЭФФИЦИЕНТ**



**СУРГАЛТАНД ХАМРАГДСАН АЖИЛТНЫ ТОО**



**Багануур ХК**

Монгол улсын эрчим хүчний нүүрсний 60%-ийг хангадаг




60%



**Багануур ХК**

Улс орнуудын эрчим хүчний үнэ



Эрчим хүчний нүүрсний үнэ





## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН МЭНДЧИЛГЭЭ

2020 он “Багануур” ХК-ийн үйл ажиллагаа, хөгжлийн түүхэнд бодитоор бичигдэн үлдэх томоохон ажлуудыг хийж бүтээсэн жил боллоо.

Компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, уурхайн үйл ажиллагаа, компанийн эдийн засаг, санхүүгийн байдлыг сайжруулах, тоног төхөөрөмжийг шинэчлэх чиглэлээр томоохон ажлуудыг зохион байгуулах шийдвэр, чиглэлүүдийг өгч, хяналт тавин, менежментээр ханган ажиллаа.


Багануурын стратегийн орд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр “Багануур” ХК-ийн удирдлагууд томоохон ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашид толгой компани болон компанийн удирдлагын зүгээс техник технологийн шинэчлэлийг иж бүрэн цогцоор нь шийдвэрлэхээр Монгол Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр, Уул, уурхай хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, толгой компанитай хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр “Эрдэнэс Монгол” нэгдэл Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны банкны 29,7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр “Багануур” ХК-д техник тоног

төхөөрөмжийн шинэчлэл хийх гэрээ байгуулсан.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Эрдэнэс Монгол” компанийн нэгдлийн хэмжээнд хэрэгжүүлэх томоохон төслүүдийг дурдвал Багануурын ордод эрчим хүч үйлдвэрлэх станцын төсөл хэрэгжүүлэх, гүн боловсруулалтын төсөл хэрэгжүүлэх, конвейрын систем нэвтрүүлэх, техник шинэчлэлийн төслүүд байна. Эдгээр арга хэмжээ, төслийг амжилттай хэрэгжүүлэхэд “Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс шаардлагатай дэмжлэгийг үзүүлэн эрх бүхий байгууллага, толгой компани болон “Багануур” ХК-ийн уялдааг ханган ажиллана.

Та бүхний ажил үйлсэд өндөр амжилт хүсэж, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

“Багануур” ХК-ийн ТУЗ-ийн дарга



Ц.БАТСАЙХАН

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ц.БАТСАЙХАН

Нэгдсэн удирдлага хариуцсан дэд захирал, Эрдэнэс Монгол ХХК

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Ч.ДОНДОГМАА

Ахлах референт, Засгийн газар

Б.ОСОРГАРАВ

Хараат бус гишүүн

М.ЦЭНГЭЛ

Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Эрдэнэс Монгол ХХК

Л.ЭРДЭНЭБИЛЭГ

Хараат бус гишүүн

Г.НАНДИНЖАРГАЛ

Төрийн нарийн бичгийн дарга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Х.ГЭРЭЛТ-ОД

Хараат бус гишүүн

Г.ЗОЛБОО

Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Сангийн яам

Б.ОЧБАДРАХ

Хараат бус гишүүн

Д.ДАВААСҮРЭН

Түлшний хангамжийн хэлтсийн дарга, Эрчим хүчний яам

М.ОТГОНБАЯР

МНСС ХХК-ийн төлөөлөл


Д.ЧИНБАТ

МНСС ХХК-ийн төлөөлөл



МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ  
НҮҮРС  
60%






## КОМПАНИЙН ТУХАЙ

“Багануур” ХК нь анх 1978 онд 200.0 мян.тн нүүрс олборлох хүчин чадалтай “Багануурын нүүрсний түр уурхай” нэртэйгээр гараагаа эхэлж, эдүүгээ 42 дэх жилдээ ажиллаж байна. Монгол улсын эрчим хүчний нүүрсний хэрэгцээний 60 хувь, төвийн бүсийн эрчим хүчний нүүрсний хэрэгцээний 70 хувийг дангаараа хангадаг нүүрсний ил уурхай юм.

Нүүрсний орд нь зүүн хойноос баруун урагш чиглэсэн суналтын дагуу уртаараа 12 км, өргөнөөрөө 4-5 км талбай эзэлж мульд маягаар тогтсон үндсэн 3 давхаргаас бүрдэнэ. Багануурын нүүрс нь эрчим хүчний зориулалттай Б2 маркийн нүүрсэнд хамаарна. Нүүрсний үнслэг нь 12-17%, чийглэг нь 28-33%, хүхрийн агуулга нь 0.4%, дулаан гаргах илчлэг нь 3200-3600 ккал/кг.

1978 онд баталсан тооцоогоор нүүрсний нөөц 599.0 сая.тн 1988 онд нарийвчилсан хайгуул хийж ордын баялаг нөөцийг 708.2 сая.тн болгосон. 2014-2015 онд Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар Багануурын нүүрсний ордын гүйцээх хайгуулын ажил хийгдэж балансын нөөцийг 280,0 сая.тн-оор нэмэгдүүлж Олон улсын JORC стандартаар үнэлэгдсэн нийт 812,0 сая.тн баталгаат нүүрсний нөөцтэй болсон.

## ЭРХЭМ ЗОРИЛГО



Тогтвортой хөгжлийг хангасан, мэдлэг инновацид суурилсан үндэсний тэргүүлэгч компани болно

## АЛСЫН ХАРАА



Монгол Улсын нүүрсний салбарын чиг хандлагыг тодорхойлогч байна

## ҮНЭТ ЗҮЙЛ

### АЮУЛГҮЙ БАЙДАЛ



Бид хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг нэн тэргүүнд тавьдаг

### САНААЧЛАГЧ, БҮТЭЭЛЧ, СУРАЛЦАГЧ



Бид мэргэжилдээ хүндэтгэлтэй хандан санаачлагатай байж шинэ шийдэл ажлын шинэ арга замыг бүтээлчээр хөгжүүлж мэргэжлийн өндөр төвшинд үйл ажиллагаа явуулахын тулд мэдлэг үр чадвараа байнга дээшлүүлдэг.

### ШУДАРГА ҮНЭНЧ



Бид зөв зүйлийг хийж, шударга ил тод байдаг. Өөртөө болон бусдад зарчимч байдлаар хандаж шударга бус байдалтай үл эвлэрнэ.

### ХАРИУЦЛАГА



Бид үүрэг хариуцлагаа ухамсарлаж хийж буй үйлдэл хэлсэн үгэндээ эзэн болдог.


### БАГИЙН АЖИЛЛАГАА, ХАМТЫН ХҮЧ



Бид харилцан итгэлцэл хүндлэлийг бий болгон хүн бүр багийн нэг хэсэг болж үр дүнтэй хамтран ажилладаг.

## БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Компанийн бүтэц, зохион байгуулалтыг ТҮЗ-ийн 2020 оны 27 дугаартай тогтоолоор баталсан “Бизнес төлөвлөгөө батлах тухай” тогтоол болон Гүйцэтгэх захирлын 2020 оны Б/14 дугаартай тушаалаар тус тус баталж, 7 хэлтэс, 3 алба, 9 хэсгийн нийт 1128 хүний орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.



## КОМПАНИЙН УДИРДЛАГА

**Э.НОМИНЧУЛУУН**  
Гүйцэтгэх захирал

**Д.ТҮВШИНЖАРГАЛ**  
Тэргүүн дэд захирал

**Н.БАЗАРСҮРЭН**  
Үйлдвэр технологи эрхэлсэн дэд захирал

**П.ЭРДЭНЭЦОГТ**  
Техникийн бодлого эрхэлсэн дэд захирал

**Ж.БАЖУНА**  
Хүний хөгжил судалгаа эрхэлсэн дэд захирал

**Д.ГАНЗОРИГ**  
Санхүү хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал

**Ч.НАРАНБАТ**  
Технологийн бодлогын хэлтсийн дарга

**Х.ХАШБАТ**  
Техникийн бодлогын хэлтсийн дарга

**А.ЭНХБОЛД**  
Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хэлтсийн дарга

**Б.БАТБОЛД**  
Захиргаа хүний нөөц удирдлагын хэлтсийн дарга

**Д.БОЛД**  
Санхүү эдийн засаг бодлогын хэлтсийн дарга

**С.БАТХИШИГ**  
Худалдаа хангамж хариуцсан хэлтсийн дарга

**Ц.ЭНХБАТ**  
Судалгаа хөгжлийн хэлтсийн дарга

**МОНГОЛ УЛСАД  
Х А М Г И Й Н  
АНХНЫ  
НӨХӨН СЭРГЭЭЛТ  
ХИЙСЭН УУРХАЙ**


**192,5 га ТАЛБАЙГ  
НӨХӨН СЭРГЭЭВ**

## БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

Уул уурхайн салбарт 1999 онд ХАМГИЙН АНХ ҮДАА нөхөн сэргээх ажлыг эхлүүлсэн бөгөөд, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалах, байгаль орчныг хамгаалах, дүйцүүлэн хамгаалал, нийгмийн хариуцлагын хүрээнд нэлээдгүй ажлуудыг хийгээд байна.

Жил бүрийн байгаль орчныг хамгаалах ажлыг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр боловсруулж БОАЖЯ-аар батлуулан төлөвлөгөөний биелэлтийг Нийслэлийн байгаль орчны газраас комисс томилогдон шалган дүгнэж байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт




### АГААРЫН ЧАНАР

Орчны тоосжилтыг уурхайн орчинд улирал тутам 3 цэгт хэмждэг байсан бол 2018 оноос нийт 5 цэгт улирал тутам, 2020 оноос 2 сар тутам 6 цэгт хэмжилтийг хийж байна. Тоосны хэмжилтээс үзэхэд 1 болон 12-р


сард/хүйтний улиралд/ стандартаас давсан бөгөөд ялангуяа дүүргийн төв зайдгайн хэсэг нь нэлээд өндөр байна. 3-9-р саруудад бүх цэгүүдэд стандарт түвшинд хэвийн байна.

Агаарын чанар



Агаар дахь тоосжилтыг бууруулах гол ажил бол зам засвар, усалгааны ажил юм. Зам усалгаанд 2-11-р сар хүртэл 4 машин ажиллаж байна. 2020 онд нийт 56,499км замыг 14,3560 тн усаар усаллаа.

Зам усалгааны ажил /литр/



### ХӨРСНИЙ БОХИРДОЛ



2020 онд Байгаль орчин нөлөөллийн үнэлгээний тайланд тусгагдсаны дагуу агрохими, хүнд металлын үзүүлэлтийг жилд 1 удаа, нефтийн агууламжийг 3 удаа хийлгэсэн. Нийт 30 дээж авч шинжлүүлсэн. Хүнд металлын хэмжээ стандарт хэмжээнд байна. 2020 онд нийт 23.1мян.м3 шимт хөрсийг хуулж, 13.4 мян.м3 шимт хөрсийг ачиж нөөцөлсөн.

Шатах тослох материалаар бохирдсон хөрсийг цуглуулах савыг асгарч болзошгүй эрсдэлтэй газруудад байрлуулж, хөрс саармагжуулах бодисыг ажлын талбайд байрлуулмаа.


Бетонон хучилттай бохир хөрс саармагжуулах талбайг байгуулсан. Эхний бохирдсон хөрсийг буулгаж хөрсний дээжийг авч шинжилгээнд өгч, хөрснөөс дээжлэн авч, хөрс ариутгалын био тамир бодисыг цацаж туршин хадгалж байна.

### УСНЫ ЧАНАР

Уурхайн шүүрүүлэлтийн усаар Багагүн нуур, Хужирт, Хуцаа голуудыг тогтмол тэжээдэг. 2020 онд Хуцаа голд 356.6 мян.м3, Хужиртын голд 1,417 мян.м3 шүүрүүлэлтийн усыг тогтмол цутган ундаргыг нөхөн сэргээсэн.

2020 онд Багагүн нуурыг шүүрүүлэлтийн усаар тэжээх ажлыг 4-р сараас эхлэн 9-р сарыг дуустал 197.8 мян.м3 усаар тэжээсэн. Багагүн нуурын усны түвшин, талбай, хөдөлтийн гүн зэрэг судалгааны ажлыг хийж байна.

Цутгасан усны хэмжээ /м3/



Багагүн нуурын усны түвшин, талбай, хөдөлтийн гүн зэрэг судалгааны ажлыг хийж байна.




- Хөдөлтийн гүнийг 3 цэгт тодорхойлсон
- 1-р цэг гүн 215см, хөдөлт 90см
  - 2-р цэг 261см, хөдөлт 105см
  - 3-р цэг гүн 233см хөдөлт 100см
  - Нуурын гүний дундаж 236см буюу хөдөлтийн дундаж 98см, хөдөөгүй үе 138см байна.

### ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал гардаг. Энгийн хог хаягдлыг дүүргийн төвлөрсөн төв хогийн цэгт гэрээ байгуулан хаяж байна. Үйлдвэрлэлийн хог хаягдлыг 2 дахь түүхий эдэд цуглуулан ангилан хадгалж байна. 2 дахь түүхий эдэд хадгалагдаж буй хог хаягдлыг хадгалах, зарцуулах, устгах ажлыг журмын дагуу зохицуулж байна.

2020 онд 33 төрлийн хог хаягдлыг сэлбэг болон бусад зориулалтаар дахин ашигласан.

Хог хаягдлыг дахин ашиглалт /ширхэг/



### УРГАМАЛ, АМЬТНЫ АЙМАГ

Уурхайн эдэлбэр талбай болон түүний орчмын ургамалжилтын судалгаа хийсэн. Эдэлбэр талбай дахь ан амьтны судалгааг “Амьтан асралт” ХХК-иар гэрээ байгуулан судалгааг хийлгэсэн.

Уурхайн эдэлбэр талбайд нийт 27 овгийн 74 зүйл ургамал бүртгэгдсэн. Нийт ургамлын 50%-ийг хуурайсаг ургамал эзэлж үетэн,

нийлмэл цэцэгтэн, буурцагтан голлосон ургамал байна. Биологийн ургац уурхайн эдэлбэр нөхөн сэргээсэн талбайд 12,5-14,5ц/га бол хот суурин газар 5,4-5,9 ц/га буюу маш их талхлагдсан байна.

Амьтны тооллогоор 27 зүйл хөхтөн амьтан, 282 зүйл шувуу, 2 зүйл хоёр нутагтан, 1 зүйлийн гүрвэл бүртгэгдсэн.



### НӨХӨН СЭРГЭЭЛТ

Нөхөн сэргээлтийн ажлыг 21 жилийн хугацаанд нийтдээ 192.5 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн. Үүнээс 100 га талбайг орон нутгийн захиргаанд хүлээлгэн өгсөн. Жилд дунджаар 10 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийхэд 400-500 сая төгрөгийг зарцуулдаг.

Түүнчлэн нөхөн сэргээлт, тохижилтын ажлын хүрээнд жилд дунджаар 2000-3000 орчим ширхэг мод бут тарьж, 200-300 м2 талбайг цэцэгжүүлэн ногоон байгууламжийг бий болгодог.

Нийслэлийн байгаль орчны газраас уурхайн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 2016 оноос эхлэн жил бүр ажлын хэсэг гарган шалгаж байна. 2020 онд “Багануур” ХК 94% үнэлгээтэй хангалттай дүн авсан.

**“ 1999 оноос 2020 он хүртэл 192,5 га нөхөн сэргээлт хийж, 2019, 2020 онд 4,638 ширхэг мод тарьсан.**

**ЧАДВАРЛАГ БОЛОВСОН  
ХҮЧИН, ТУРШЛАГАТАЙ  
ХАМТ ОЛОН**



**1128**

**АЖИЛТНЫГ  
АЖЛЫН БАЙРААР  
ХАНГАЖ БАЙНА.**

## ХҮНИЙ НӨӨЦ

### 1. ЭРҮҮЛ УУРХАЙЧИН

“Өв тэгш бие бялдартай, эрүүл зохистой хоолмолтой, амьдралын зөв дадалтай эрүүл уурхайчныг хувь хүний оролцоо, байгууллагын дэмжлэгтэйгээр төлөвшүүлэх” зорилгын хүрээнд 2020 онд “Эрүүл уурхайчин” хөтөлбөрийн төлөвлөгөө гарган Хөдөлгөөн, Эрүүл хоолмолт, Эрүүл мэнд гэсэн 3 үндсэн чиглэлээр хэрэгжилтийг ханган ажиллалаа.

ХӨДӨЛГӨӨН      ЭРҮҮЛ  
ХООЛМОЛТ      ЭРҮҮЛ  
МЭНД



### 2. БОЛОВСРОЛТОЙ УУРХАЙЧИН

2020 онд Сургалт хөгжлийн төлөвлөгөөг Удирдах ажилтнуудын манлайлал, инженер техникийн ажилтан нарыг мэргэшүүлэх, ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх, үр чадвар нэмэгдүүлэх гэсэн 3 зорилтын хүрээнд сургалтуудыг төлөвлөн ажилласан ба нийт 3469 ажилтан /давхардсан тоогоор/ 32 цагийн /дунджаар/ сургалтанд хамрагдаж 77,2% гүйцэтгэлтэй ажилласан байна.



Ажилтан сургалтанд хамрагдсан /давхардсан тоогоор/

**3469**

### 3. ЗӨВ ҮЗЭЛ ХАНДЛАГАТАЙ УУРХАЙЧИН

Ажилтнуудаас байгууллагын соёл, сэтгэл ханамжийн судалгааг хөндлөнгийн байгууллагатай хамтран үнэнч байдал, байгууллагын зорилго зорилтоо хэрхэн ойлгож түүнд хувь нэмрээ хэрхэн оруулдаг, байгууллагынхаа соёлыг удирдах болон гүйцэтгэх түвшинд хэрхэн хардаг, мөн ажилчдын сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлох, сэтгэл ханамжид нөлөөлөгч гол хүчин зүйлсийг нарийвчлан судлахад түүвэр байдлаар тоон болон чанарын судалгааг хийсэн. Тус судалгааны үр дүн ажилтнуудын сэтгэл ханамж өндөр, зөв үзэл хандлага төлөвшсөн үр дүнтэй гарсан.

### 4. ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХТАЙ УУРХАЙЧИН

Багануур ХК-н төлөөлөн удирдах зөвлөлийн дугаар 37-р тогтоолоор компанийн тухай хуулийн 76-р зүйл, Багануур ХК-ийн дүрмийн 10-р зүйлийг үндэслэн 2020 оны 1-р сарын 1-ний өдрөөс үндсэн цалинг 10%-иар нэмэгдүүлсэн.




Үндсэн цалинг **10%-иар** нэмэгдүүлсэн


## ХҮНИЙ НӨӨЦИЙН СТАТИСТИК



**30%** Дээд  
**10%** Тусгай дунд  
**54%** Бүрэн дунд  
**6%** Бүрэн бус дунд



**18-23** насны **2%**  
**24-39** насны **51%**  
**40-55** насны **42%**  
**56-60** насны **5%**



86%      14%

Эмэгтэй ажилтнуудын 9% нь удирдах түвшинд ажилладаг.




Ажилласан жил /хувиар/  
**0-5** жил 27%  
**6-15** жил 42%  
**16-с** дээш жил 31%

## ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРОО

Ажилтнуудын сайн дурын үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хороотой бөгөөд жил бүр хамтын гэрээ байгуулан ажилладаг.

### Үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хороотой байгуулсан хамтын гэрээний биелэлт



**НЭН ТҮРҮҮНД  
АЮУЛГҮЙ  
БАЙДАЛ**



**2,2**

**САЯ  
ХҮН ЦАГ  
ОСОЛГҮЙ**



## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙ

### БОДЛОГО БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Багануур ХК нь ХАБЭА-н хуулийн заалтыг хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг аюулгүй явуулах, ажилтнаа хамгаалах зорилгоор ХАБЭА-н удирдлагын тогтолцооны олон улсын стандартын хүрээнд ХАБЭА-н бодлогыг боловсруулан хэрэгжүүлж байна.



Гүйцэтгэл  
**98%**

### ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бид 2017 оноос эхлэн OHSAS 18001:2012 олон улсын стандартын дагуу менежментийн нэгдсэн тогтолцоог үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд ХАБЭА-н бодлого, түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан, жил бүрийн төлөвлөгөөгөөр тодотгон ажилладаг ба 2020 онд 6 чиглэлээр 26 заалттай төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажилласан, төлөвлөгөөний биелэлт 98,8%-тай.


Стандартыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, гарааны дүн шинжилгээ хийх, бодлого, зорилт, хөтөлбөрийг боловсруулах, ажилтнууддаа таниулах, журам зааврыг шинэчлэх, шинээр боловсруулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн хэмжилт мониторинг хийх, дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээ хийх, дахин сайжруулах зэрэг бүх үе шатуудыг амжилттай хэрэгжүүлэн цаашид эрх бүхий байгууллагаар ISO45001 стандартаар баталгаажуулалт хийлгэх зорилт тавин ажиллаж байна.

Тайлант онд ХАБЭА-н удирдлагын тогтолцооны хэрэгжилтийг хянах, хууль эрх зүйн нийцэл, үр дүнд аудит хийх, цаашид сайжруулах, нөөцийг гүйцэтгэх удирдлагаас үнэлж баталгаажуулахтай холбоотой

харилцааг зохицуулах зорилгоор “ХАБЭА-н үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хэмжилт, мониторинг хийх журам”, “ХАБЭА-н удирдлагын тогтолцоонд аудит хийх журам”, ХАБЭА-н удирдлагын тогтолцоонд удирдлагын дүн шинжилгээ хийх журам” зэргийг шинээр боловсруулсан.

Компанийн үндсэн 9 хэсгийн 963 ажилтан, 135 ажлын байр, 59 ахуйн байрыг хамруулан 2 удаагийн мониторингийг хийж, Гүйцэтгэх удирдлагад танилцуулсан бөгөөд мониторингоор авбал зохих 15 онооноос 12,2 оноог авч бага эрсдэлтэй буюу 81,3%-тай үнэлэгдсэн.

2020 оны осолгүй ажилласан цаг 2,246,153 хүн/цаг, алдагдсан хугацааны ослын давтамж прокси хэмжилтээр 0% гарсан.



**2,2**

Сая хүн/цаг


## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТ

ХАБЭА-н сургалтыг Хөдөлмөрийн сайдын 2019 оны А/370 тоот тушаалд заасан үлгэрчилсэн хөтөлбөрийн дагуу 9 үндсэн, 34 дэд сэдвийн хүрээнд 12 цагийн багтаамжтай хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж эхний хэсгийн сургалт, шалгалтыг 5 болон 6 дугаар сард цар тахлын онцгой нөхцөл байдал нийцүүлэн цахимаар, хоёрдугаар хэсгийн сургалт, шалгалтыг 10 дугаар сард тахимаар явуулсан. Сургалтанд давхардсан тоогоор


1960 ажилтныг хамруулахаас 1913 буюу нийт ажилтны 97.6%-ийг хамруулсан. Шалгалтанд 980 ажилтан хамрагдахаас 975 ажилтан хамрагдаж, 900 ажилтан тэнцсэн, сургалтын чанар 90,8%-тай.

Эмнэлгийн анхны тусламж, гал эсэргүүцэх болон аваар устгах дасгалыг компанийн 11 цэгт зохион байгуулж 782 ажилтныг хамруулсан, хамрагдалт 75%-тай байна.

### ХАБЭА-н сургалтын хамрагдалт



### ХАБЭА-н шалгалтын хамрагдалт, чанар




### ХЯНАЛТ ҮЗЛЭГ

ХАБЭА-н тасралтгүй хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэлийн удирдлагын менежментийг нэвтрүүлэх зорилгоор 2020 онд “ХАБЭА-н хяналтын журам”-д өөрчлөлт оруулж, ажлын байрны аюулыг илрүүлэх үзлэгийг тогтмол хийлгэх, үзлэгээр илэрсэн зөрчлийг арилгасны дараа ажлаа эхлэх, ажлын даалгаварт тохирсон эрсдэлд суурилсан аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, ажилбарыг технологийн картын дагуу аюул осолгүй хийлгэж хэвшүүлэх, хяналт тавих зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна. Аюулыг мэдээлэх хуудсаар 2020 онд нийт 514 зөрчлийн мэдээлэл ирсэн, зөрчил


арилгалт 97%, ХАБЭА-н III шатны ээлжит үзлэгийг ковид-19 цар тахлаас шалтгаалж 2 удаа хийсэн бөгөөд 96 зөрчил илэрч 97%-ийн гүйцэтгэлтэй арилгуулсан. Нийт 148 удаагийн ээлжит бус үзлэгээр 235 зөрчил илэрч зөрчлийн 92%-ийн гүйцэтгэлтэй арилгасан. Нийт 500 эрсдэлийн үнэлгээг шинэчлэн батлуулж, тогтмол хянан ажиллаж байгаа бөгөөд 2020 онд 35 ажлын байрны эрсдэлийг бууруулсан байна.

Түүнчлэн ажилтнуудад зориулсан ХАБЭА, аюулгүй ажиллагаа, осол, эрсдэлийн менежмент, анхны тусламжийн сургалт, зааварчилгаанууд тогтмол хийгдэж байна.


Мэдээлсэн аюул эрсдэлийн тоо, арилгалтын хувь




Осолд дөхсөн тохиолдол




### Ээлжит үзлэгээр илэрсэн зөрчлийн тоо



### Ээлжит бус үзлэгээр илэрсэн зөрчлийн тоо



### Үйлдвэрлэлийн осол



**ОРОН НУТАГ  
ХАМТЫН  
АЖИЛЛАГАА**



**АЖЛЫН ХУЦАС  
ХУДАЛДАН АВАЛТ**

**856,8**  
**САЯ.ТӨГ**


## ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ БА НИЙТИЙН ОРОЛЦОО

Хариуцлагатай уул уурхайн сайн дурын кодексийг хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичигт зааснаар “Багануур дүүргийн Төр захиргааны байгууллага, “Багануур” ХК-ийн хоорондын хамтын ажиллагааны “Санамж бичиг”-ийг зурж, дүүргийн төр захиргааны байгууллагатай хамтран ажиллаж, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхээр тодорхой ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:

- Багануур дүүргийн зорилтот бүлгийн өрхөд 60 тонн нүүрсний тусламж үзүүлсэн.
- Дүүргийн харьяат хүнд өвчний улмаас гадагш явж эмчлүүлэх шаардлагатай хүмүүст болон гамшигт өртөж орон гэргүй болсон өрхөд уурхайчид бид аян өрнүүлэн хамт олноороо хандив тусламж үзүүлсээр ирсэн.

- “Миний бэлэглэсэн цус - Гурван хүнд амьдрал бэлэглэнэ” аяныг зохион байгуулсан.
- Дүүргийн Захирагчийн албатай хамтран “Өгөөмөр өдөр” аяныг өрнүүлэн хувцас, эд зүйлс, хичээлийн хэрэгслийг цуглуулан дүүргийн зорилтод бүлгийн өрхүүдэд тусалсан.
- Эрүүл мэндийн үзлэгт нийт ажилчдыг хамруулах ажилд дүүргийн эрүүл мэндийн нэгдэлтэй хамтран ажиллаж, 85,0 сая төгрөгийн гэрээ байгуулан ажилласан.
- Багануур дүүргийн эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах зорилгоор ЖДҮ –ийг дэмжих төв, “Их үйл” оёдолчдын холбоогоор дамжуулан өвөл, зуны ажлын хувцас, бээлийг хийлгэж эмэгтэйчүүдийнхээ эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлдэг.

Орон нутгаас ажлын хувцас худалдан авалт



## НИЙГЭМ, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

2020 оны төсөвт төлөх төлбөр 34.2 тэрбум төгрөг байгаагаас 24.4 тэрбум төгрөг нь байгууллагаас, 9.5 тэрбум төгрөг нь ажилтан албан хаагчдаас төлөгдсөн байна. Нийт төсөвт төлөх төлбөрийн 51.4 хувь нь Улсын төсөвт 2,4 хувь нь нийслэл, 44.6 хувь нь дүүрэг орон нутагт төвлөрүүлсэн. 2020 онд нийгмийн хариуцлагын хүрээнд дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт орших “Уурхайчин” хотхоны орон сууцны барилгуудын гадна фасад шинэлэх ажил” -ыг өөрийн хөрөнгө оруулалтаар 558.6 сая төгрөг зарцуулан их засвар хийж амжилттай хэрэгжүүлээд Улсын комисст хүлээлгэж өгсөн.

Үүнд:  
9 давхар угсармал 4 орон сууцны барилга  
5 давхар угсармал 3 орон сууцны барилга



## ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАЛ


Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын “Аварга тосон” нуурын орчимд дүйцүүлэн хамгааллаар эмчилгээний шар шаврын хэсгийг хашаажуулан, сүүдрэвч барьж орон нутагт хүлээлгэн өгсөн. Төв аймгийн Баяндэлгэр сумын “Гүн галуутай” орон

нутгийн тусгай хамгаалалтай газар нутагт дүйцүүлэн хамгааллаар ан амьтан хамгаалах, загасчлалд хяналт тавих цэг, 5-6м өндөртэй махчин шувууд суух цэг 4ш хийж байрлуулан орон нутагт хүлээлгэн өгсөн.





**ТАТВАР**  
**24,3**  
**ТЭРБУМ ТӨГРӨГ**

  
**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**  
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

**БАГАНУУР ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ЗАХИРАЛ  
Э.НОМИНЧУЛУУН ТАНАА**

2021.03.15 № 07/828  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Багануур" ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Багануур" ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтийн тайланд нийт 17 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


110.10.10.20\Bichia KheredYewsee\Bichia\2021\0315audit\2-R\Gazar\97.Docx  
001052020

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР 

Ц.НАРАНЧИМЭГ

110.10.10.20\Bichia KheredYewsee\Bichia\2021\0315audit\2-R\Gazar\97.Docx  
01

"Багануур" ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,036,934,401.99	703,196,034.90
1.1.2	Дансны авлага	12,756,011,354.94	8,835,659,448.61
1.1.3	Татвар, НДШ –ийн авлага	531,044,878.07	316,639,700.00
1.1.4	Бусад авлага	26,700,000.00	54,240,000.00
1.1.6	Бараа материал	30,441,076,183.52	30,884,314,517.53
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,603,337,204.15	6,418,877,568.34
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>54,395,104,022.67</b>	<b>47,212,927,269.38</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	101,118,629,971.33	165,059,365,142.15
1.2.2	Биет бус хөрөнгө	4,766,625,348.72	4,834,544,397.25
1.2.3	Уул уурхайн хөрөнгө /УУ хөгжүүлэлт, хөрс хуулалт/	24,201,882,420.40	27,640,437,061.90
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	999,767,331.34	999,767,331.34
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	764,393,387.00	764,393,387.00
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>131,851,298,458.79</b>	<b>199,298,507,319.64</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>186,246,402,481.46</b>	<b>246,511,434,589.02</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	51,378,313,611.13	54,087,662,554.73
2.1.1.2	Цалингийн өглөг	1,551,511,014.35	1,736,003,144.00
2.1.1.3	Татварын өр	24,040,668,565.45	30,158,365,547.33
2.1.1.4	НДШ –ийн өглөг	3,951,779,921.79	6,285,057,598.83
2.1.1.5	Богино хугацаат зээл	51,891,576,198.24	47,043,663,499.59
2.1.1.6	Хүүгийн өглөг	460,374,348.92	1,152,844,932.18
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	12,971,933.50	12,971,933.50
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,744,854,966.01	2,075,165,788.45
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>135,032,050,559.39</b>	<b>142,551,734,998.61</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	28,687,562,419.95	23,847,436,176.35
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	1,167,266,443.09	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	9,094,470,397.46	-
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>38,949,299,260.50</b>	<b>23,847,436,176.35</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>173,981,349,819.89</b>	<b>166,399,171,174.96</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>2,097,436,000.00</b>	<b>2,097,436,000.00</b>
2.3.1	Өмч-төрийн	1,573,077,000.00	1,573,077,000.00
2.3.2	хувийн	524,359,000.00	524,359,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	60,685,388,076.98
2.3.9	Хуримтлагдсан ашиг	10,167,616,661.57	7,672,308,688.50
2.3.10	Тусга зориулалтын нөөцийн сан		9,657,130,648.58
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>12,265,052,661.57</b>	<b>80,112,263,414.06</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>186,246,402,481.46</b>	<b>246,511,434,589.02</b>


 "Багануур" ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	138,536,533,328.54	140,370,562,061.13
2	Борлуулалтын өртөг	131,526,746,086.30	128,280,316,426.01
3	<b>Нийт ашиг(алдагдал)</b>	<b>7,009,787,242.24</b>	<b>12,090,245,635.12</b>
4	Түрээсийн орлого	54,395,427.24	22,827,202.24
5	Хүүгийн орлого	23,308,226.49	16,596,136.98
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	2,651,665,660.17	2,601,578,569.01
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	9,069,398,278.78	16,145,317,312.14
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	592,055,754.16	587,923,734.19
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-294,073.74	776,207.43
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-12,358,104.29
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>77,408,449.46</b>	<b>-2,013,575,399.84</b>
19	Орлогын татварын зардал	7,740,844.95	1,659,613.70
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>69,667,604.51</b>	<b>-2,015,235,013.54</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>69,667,604.51</b>	<b>-2,015,235,013.54</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>69,667,604.51</b>	<b>-2,015,235,013.54</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		



"Багануур" ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/						
Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Тусгай зориулалтын нөөцийн сан	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00				10,494,662,887.71	12,592,098,887.71
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00				10,494,662,887.71	12,592,098,887.71
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					69,667,604.51	69,667,604.51
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-396,713,830.65	-396,713,830.65
Зарласан ногдол ашиг						
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00				10,167,616,661.57	12,265,052,661.57
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-480,072,959.53	-480,072,959.53
Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00			9,657,130,648.58	9,687,543,702.04	21,442,110,350.62
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					-2,015,235,013.54	-2,015,235,013.54
Зарласан ногдол ашиг						
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			60,685,388,076.98			60,685,388,076.98
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00		60,685,388,076.98	9,657,130,648.58	7,672,308,688.50	80,112,263,414.06



"Багануур" ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	129,020,657,650.61	142,589,873,234.50
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	128,679,217,785.61	142,303,901,493.49
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар	300,542,063.91	250,581,086.42
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	40,897,801.79	35,390,654.59
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	118,567,530,323.79	107,953,761,972.24
	Ажиллагчдад төлсөн	31,532,561,664.45	30,849,751,113.26
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	6,750,447,898.00	7,676,337,451.03
	Бараа материал худалдан авахад төлсөн	42,817,530,349.92	37,536,473,861.15
	Ашиглалтын зардалд төлсөн		
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	23,632,819,675.49	18,332,491,561.85
	Хүүгийн төлбөрт төлсөн	963,223,160.80	1,054,999,032.11
	Татварын байгууллагад төлсөн	9,962,857,878.13	10,291,306,443.64
	Даатгалын төлбөрт төлсөн	109,287,000.00	7,565,715.00
	Бусад мөнгөн зарлага	2,798,802,697.00	2,204,836,794.20
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	10,453,127,327.52	34,636,111,262.26
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	23,308,226.49	16,596,136.98
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүгийн орлого	23,308,226.49	16,596,136.98
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,256,297,973.70	26,924,919,592.60
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	10,104,021,483.70	26,589,346,904.60
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	152,276,490.00	335,572,688.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	10,232,989,747.21	26,908,323,455.62
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,800,763,651.46	4,350,806,904.97
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	4,800,000,000.00	4,349,999,834.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		





"Багануур" ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн  
 санхүүгийн тайлангийн аудит

	Төрөл бүрийн хандив		
	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	763,651.46	807,070.97
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>5,597,777,076.37</b>	<b>13,412,271,351.62</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	5,597,621,896.27	13,412,302,215.16
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	155,180.10	30,863.54
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>797,013,424.91</b>	<b>9,061,526,173.73</b>
4	Валютын ханшийн зөрүү		
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-576,875,845.30</b>	<b>-1,333,738,367.09</b>
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,613,810,300.27	2,036,934,401.99
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,036,934,401.89	703,196,034.90

